



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/306

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Түр амрах цэг шинээр байгуулах (Булган сум)” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Гурван уулын хишиг” ХХК-тай 68,500,000 (жаран найман сая таван зуун мянган) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Гурван уулын хишиг” ХХК-ийн захирал (Д.Мягмардорж)-д даалгасугай.

3. Хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Булган аймгийн Автотээврийн төвийн дарга (Н.Баасанжаргал)-д даалгасугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Цэдэнлхам)-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010432

Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 12-ны/ний өдрийн
А/306 дугаар захирамжийн хавсралт

Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1.	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	С.Цэдэнлхам
2.	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	С.Цэдэнлхам
3.	Магадлашгүй ажил	1,206,886	Ү.Бямбасүрэн
4.	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	603,443	Ү.Бямбасүрэн
5.	Нормчлолын сан	108,620	Ү.Бямбасүрэн
6.	Захиалагчийн техник хяналтын зардал	1,206,886	Ү.Бямбасүрэн
7.	Ажлыг хийж гүйцэтгэх хугацаа	35 хоног	Ү.Бямбасүрэн